



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/553

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын “б” дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 76 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны ээлжит бус Х хуралдааны 01 дүгээр тогтоолын 04 дүгээр хавсралт, “Хөгжлийн хөтөч” аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол улсад Атар газар эзэмшиж, газар тариаланг шинжлэх ухааны үндэслэлтэй бие даасан салбар болгон хөгжүүлсний түүхэн 60 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдах үндэсний бөхийн барилдааны зардалд 2,176,000 (Хоёр сая нэг зуун далан зургаан мянган) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын “Хөдөө аж ахуй хөгжлийн тулгуур” дэд хөтөлбөрт батлагдсан төсвөөс санхүүжүүлэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Э.Аззаяа), Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Базар) нарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД